


БИДНИЙ АЖИГЛАЛТАД БҮЙ ХУВЬЦААНУУД

ГОЛОМТ КАПИТАЛ:

ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА,
СУДАЛГААНЫ ГАЗАР

7-р сар





CVS Health
NYSE: CVS

Reuters зорилтот ханш:
USD 67.1 (+13.61%)

Зөвлөмж:
Авах

Компанийн хураангуй:

CVS Health Corp. нь АНУ-ын томоохон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч компани юм. Энэхүү компани нь 1963 онд Массачусеттс мужид ах дүү Голдштайн болон Ральф Хоагланд нараар үүсгэн байгуулагдсан байна.


CVS Health Corp. үйл ажиллагаа нь 4 сегментэд хуваагддаг бөгөөд үүнд Health Care Benefits буюу Эрүүл мэндийн даатгал, Health Services буюу Эрүүл мэндийн үйлчилгээ, Pharmacy & Consumer Wealth буюу Эмийн сан ба Хэрэглэгчтэй харилцах болон Corporate/Other буюу Байгууллагын/Бусад гэсэн хэсгээс бүрддэг.

Салбарын хураангуй:

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (OECD)-ын тооцооллын дагуу 2012-2021 онуудад АНУ-ын эрүүл мэндийн салбар дахь зарцуулалт дунджаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 16.8% байсан байна. 2022 онд АНУ-д эрүүл мэндийн бараа, үйлчилгээнд өрхийн төсвөөс 452 гаруй тэрбум ам.доллар зарцуулсан бөгөөд 2013 оноос хойш жилд дунджаар 3.41 хувиар өсөөд байна. Тус тоон үзүүлэлт хүн амын тоо болон өрхийн орлого нэмэгдэх тусам өсөх хандлагатай байдаг тул эрүүл мэндийн салбарын зарцуулалт өсөх трендтэй байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд:

CVS Health Corp компанийн 2023 оны борлуулалтын орлогын динамик:



CVS Health Corp компанийн голлох харьцаа үзүүлэлтүүд:

	2023	Салбар*
Нийт ашгийн маржин	15.21%	36.07%
EBITDA маржин	5.46%	12.66%
Үйл ажиллагааны маржин	3.84%	6.62%
Цэвэр ашгийн маржин	2.33%	2.16%
Эздийн өмчийн өгөөж	11.28%	21.34%
Нийт хөрөнгийн өгөөж	3.50%	3.15%


*Салбарын тооцооллод орсон компаниудыг Хавсралт 1-с харна уу

CVS Health Corporation компанийн 2023 оны борлуулалтын орлогын хэмжээ нь 357 тэрбум 776 сая ам.доллар хүрсэн бөгөөд үүнээс 68.52 хувь нь эрүүл мэндийн бүтээгдэхүүний борлуулалтаас хамааралтай ба 27.72 болон 3.44 хувь нь даатгал болон эрүүл мэндийн үйлчилгээний орлогоос бүрдсэн байна. Компанийн **нийт борлуулалтын орлого 2018 оноос хойш жилд дунджаар 12.95 хувь өссөн** бөгөөд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний сегмент хамгийн их буюу 64.7 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.



Үнэлгээ:

Refinitiv платформ дээр нийтлэгдсэн шинжээчдийн таамгийг авч үзвэл 2024 оны 6-р сарын байдлаар 4 шинжээч тус компанийн хувьцааг худалдан авахад нэн тохиромжтой гэж үзэж байгаа бол 10 нь худалдан авахад тохиромжтой бол 16 нь хүлээх гэсэн зөвлөмж өгөөд байна.



Эх сурвалж: Refinitiv

Эдгээр тамаг дээр үндэслэн CVS Health компанийн дундаж зорилтот ханш 67.1 ам.доллар дээр тогтож байгаа бөгөөд энэ 6-р сарын 30-ны хаалтын ханшаас 13.61 хувиар дээгүүр ханш юм.

Байгаль орчин, нийгэм, эдийн засаг:

2023 онд CVS Health компани CVS Health Foundation сан, грант, бэлэг, тэтгэмжийн хэлбэрээр 286 гаруй сая ам.долларыг хөрөнгө оруулалт, олон нийтэд зориулсан төслүүдэд зарцуулсан байна. Энэхүү санхүүжилтэд 6500 гаруй ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж болон грант хүлээн авагчид багтсан байна.

Байгаль хамгааллын салбарт тус компани 6 сэргээгдэх эрчим хүчний компанитай нийлүүлэлтийн гэрээ байгуулснаар нийтдээ 2000 байршлыг сэргээгдэх эрчим хүчээр хангаж байна. Үүнээс 5 гэрээ нь 2023 онд байгуулагдсан байгаа бөгөөд эдгээрт Техас, Иллиной, Калифорни, Мэрилэнд болон Пеннсильвани мужууд орж байна. Түүнлэн, CVS Health компани Healthy 2030 хөтөлбөрийн хүрээнд 2030 он гэхэд plastiкийн хэрэглээг 50 хувь бууруулах зорилтыг тавьсан байна.

Томоохон эрсдэлүүд:

- ❑ Макро эдийн засгийн төлөв байдал, өрсөлдөгчид болон салбарын үйл ажиллагаа
- ❑ Шинээр компани худалдаж авсантай холбоотой бизнесийн эрсдэлүүд (2023 оны хувьд Signify Health болон Oak Street Health)
- ❑ Олон нийтийн үйл ажиллагааны чиглэлүүдийг харах өнцөг, эерэг/сөрөг хандлага
- ❑ АНУ болон олон улсын эрүүл мэндийн салбар болон эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний хууль зүй болон зохицуулалт
- ❑ Зээлжих үнэлгээ буурах тохиолдолд компанийн хөрөнгө босгох боломжууд багасна
- ❑ Хамтрагч байгууллагуудаас хамаарсан нийлүүлэлтийн сүлжээний тасалдалт



CVS хувьцааны техник анализ:

abilguun published on TradingView.com, Jul 01, 2024 02:36 UTC-4

BATS:CVS, 1D, 059.00 H:59.99 L:58.47 C:59.06 +0.70 (+1.20%)




TradingView

CVS үнэ ашгийн харьцаа (P/E=10.4)

TRAILING PE

The most recent week's close price divided by the sum of the four most recently reported quarterly earnings.

Trailing PE: 10.4
5-Year Average: 17.6
S&P 500 Index Average: 28.7
Health Facilities & Svcs. Industry Average: 24.5




CVS үнэ орлогын харьцаа (P/S=0.2)

PRICE TO SALES

The most recent week's close price divided by the revenue per share.

Price to Sales: 0.2
5-Year Average: 0.4
S&P 500 Index Average: 2.9
Health Facilities & Svcs. Industry Average: 0.6



Хавсралт 1:

TRBC - Healthcare Facilities & Services

Компани

Тикер

Компани	Тикер
CVS Health Corp	CVS
HCA Healthcare Inc	HCA
Tenet Healthcare Corp	THC
Community Health Systems Inc	CYH
Labcorp Holdings Inc	LH
DaVita Inc	DVA
Quest Diagnostics Inc	DGX
Solventum Corp	SOLV.K
Select Medical Holdings Corp	SEM
Option Care Health Inc	OPCH.O
AMN Healthcare Services Inc	AMN
Pacs Group Inc	PACS.K
Chemed Corp	CHE
R1 RCM Inc	RCM.O
Aveanna Healthcare Holdings Inc	AVAH.O
Privia Health Group Inc	PRVA.O
Astrana Health Inc	ASTH.O
Natera Inc	NTRA.O
Sotera Health Co	SHC.O
CorVel Corp	CRVL.O
InnovAge Holding Corp	INNV.O



ebay
NYSE: EBAY

Reuters зорилтот ханш:
USD 52.84 (-1.64%)

Зөвлөмж:
Хүлээх

Компанийн хураангуй:

eBay Inc. нь АНУ-ын томоохон онлайн худалдааны платформ юм. Компанийн үйл ажиллагаагаараа дамжуулан 190 гаруй орны худалдагч, худалдан авагчид холбодог байна. Компани www.ebay.com сайтаас гадна АНУ болон Япон улсад бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байна.

2023 оны хувьд тус платформ дээр хамгийн их борлуулалттай байсан бүтээгдэхүүнүүдийн дунд эд анги, дагалдах хэрэгсэл, цуглуулга, загварын хувцас, электрон бараа, гэр ахуй болон цэцэрлэг тариалангийн бараа бүтээгдэхүүн орсон байна.


Салбарын хураангуй:

Онлайн худалдааны платформуудын хурдацтай хөгжлийн талаар АНУ-ын Amazon.com болон БНХАУ-ын Alibaba.com зэрэг компаниудын амжилтаас дүгнэж болж байна. Mordor Intelligence судалгааны байгууллагын тооцооллоор 2024 онд онлайн худалдааны зах зээл 8.8 тэрбум ам.доллараар хэмжигдэх төлөвтэй байгаа бол 2029 он гэхэд тус дүн 18.81 тэрбум ам.доллар хүрэх төсөөлөл байна.

Ингэснээр цар тахлын үеэр түгээмэл хэрэглээ болсон онлайн худалдааны **салбар жилд дунджаар 15.8 хувиар өснө** гэсэн хүлээлттэй байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд:

eBay Inc компанийн 2023 оны борлуулалтын орлогын динамик:



eBay Inc компанийн голлох харьцаа үзүүлэлтүүд:

	2023	Салбар
Нийт ашгийн маржин	71.98%	47.55%
EBITDA маржин	28.86%	11.64%
Үйл ажиллагааны маржин	19.20%	6.08%
Цэвэр ашгийн маржин	27.36%	4.48%
Эздийн өмчийн өгөөж	48.06%	--
Нийт хөрөнгийн өгөөж	13.07%	4.96%


*Салбарын тооцоололд орсон компаниудыг Хавсралт 2-с харна уу

eBay Inc компанийн 2023 оны борлуулалтын орлогын хэмжээ нь 10 тэрбум 11 сая ам.доллар хүрсэн бөгөөд АНУ дахь болон олон улс дахь борлуулалт ойролцоогоор тэнцүү хувийг эзэлж байгаа бөгөөд тус үзүүлэлт нь өнгөрсөн онтой харьцуулбал 3.24 хувь өссөн байна. Борлуулалтын орлого тогтвортой трендийг дагахгүй байгаа хэдий ч ашгийн маржины үзүүлэлтийг авч үзвэл эерэг дүр зураг гарч ирч байна. Тухайлбал, бусад салбаруудтай харьцуулбал онлайн худалдааны салбар харьцангуй өндөр нийт ашгийн маржинтай бөгөөд eBay Inc хувьд тус үзүүлэлт нь салбараас дэгүүр буюу 71.78 хувьтай байна. Түүнчлэн, цэвэр ашгийн хэмжээ салбараас 5 дахин илүү байна.



Үнэлгээ:

Refinitiv платформ дээр нийтлэгдсэн шинжээчдийн таамгийг авч үзвэл 2024 оны 6-р сарын байдлаар 4 шинжээч тус компанийн хувьцааг худалдан авахад нэн тохиромжтой гэж үзэж байгаа бол 6 нь худалдан авахад тохиромжтой, 21 нь хүлээх зөвлөмж өгсөн бол 2 шинжээч зарах зөвлөмж өгчээ.



Эх сурвалж: Refinitiv

Эдгээр таамаг дээр үндэслэн eBay Inc. компанийн дундаж зорилтот ханш 52.84 ам.доллар дээр тогтож байгаа бөгөөд энэ 6-р сарын 30-ны хаалтын ханшаас 1.64 хувиар доогуур ханш юм.

Байгаль орчин, нийгэм, эдийн засаг:

Нийгэм эдийн засгийн бодлогын хүрээнд eBay Inc бизнес эрхлэлтийг дэмжих үүднээс eBay Foundation сангаараа дамжуулан ашгийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг байна. 2023 онд тус компани 19 сая ам.долларын дүнтэй грант дэмжлэгийг бизнес эрхлэгчдэд олгосон байна. Харин байгал орчин хамгааллын хүрээнд 2025 он гэхэд компанийн офис, дата төвүүдийг 100 хувь сэргээгдэх эрчим хүчээр хангах зорилт тавьсан байна. eBay Inc нь Clean Energy Buyers Association зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилготой байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Түүнчлэн дахин боловсруулахуйн эдийн засгийг дэмжих үүднээс eBay Refurbished хөтөлбөрийн хүрээнд KitchenAid, Bose болон Dyson зэрэг үйлдвэрлэгч нараас сэргээн засварласан бүтээгдэхүүн захиалах боломжтой байна.


Томоохон эрсдэлүүд:

- Электрон худалдан авалтын салбарын ширүүсэж буй өрсөлдөөн
- Валютын хэлбэлзэл санхүүгийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх боломжтой
- Үйлчлүүлэгчдийн худалдан авах чадвар доройтсон тохиолдолд компанийн платформуор хийгдэж буй борлуулалт буурна
- eBay Money Back Guarantee үйлчилгээг компанийн ашигт үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх боломжтой
- Компанийн үйл тасалдалгүй үйл ажиллагаа онлайн сүлжээний тогтвортой байдал болон кибер аюулгүй байдлаас шалтгаална
- Шинээр боловсруулагдсан хууль зүйн баримт бичиг болон хувийн мэдээлэл хамгаалах хуулийн заалтууд компанийн дата цуглуулах бодлоготой сөргөлдөж болзошгүй



еВау хувьцааны техник анализ:

abilguun published on TradingView.com, Jul 01, 2024 02:45 UTC-4




TradingView

еВау үнэ ашгийн харьцаа (P/E=10.7)

TRAILING PE

The most recent week's close price divided by the sum of the four most recently reported quarterly earnings.

Trailing PE: 10.7
 5-Year Average: 15.2
 S&P 500 Index Average: 28.7
 Online Services Industry Average: 31.6




еВау 1% ашгийн өсөлтөд хани өсөх хувь (PEG=1.4)

FORWARD PEG

The Forward P/E divided by the five-year forecasted growth rate.

Forward PEG: 1.4
 5-Year Average: 1.3
 S&P 500 Index Average: 1.9
 Online Services Industry Average: 1.2



Хавсралт 2:

GICS – Broadline Retail

Компани	Тикер
Amazon.com Inc	AMZN.O
Macy's Inc	M
eBay Inc	EBAY.O
Kohls Corp	KSS
Coupage Inc	CPNG.K
Nordstrom Inc	JWN
Qurate Retail Inc	QRTEA.O
QVC Inc	QVCD.K
Dillard's Inc	DDS
ETSY Inc	ETSY.O
Bon-Ton Stores Inc	BONTQ.PK
Savers Value Village Inc	SV
Ollie's Bargain Outlet Holdings Inc	OLLI.O
Groupon Inc	GRPN.O



BorgWarner

NYSE: BWA

Reuters зорилтот ханш:
USD 41 (+27.17%)

Зөвлөмж:
Авах

Компанийн хураангуй:

BorgWarner Inc. АНУ-д төвтэй дэлхийн томоохон автомашины эд анги борлуулагчдын нэг юм. Тус компани 4 сегментэн дор үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд: Air Management (эрчим хүчний үр ашиг болон эд ангийн хүчин чадал нэмэгдүүлэх бүтээгдээхүүн), Drivetrain & Battery Systems (батерей болон удирдлагын модуль) болон ePropulsion (цахилгаан автомашины эд анги) ордог байна.


Түүнээс гадна Fuel Systems ба Aftermarket сегментүүдийг тусгаарлан шинэ хувьцаат компани болох PHINIA [NYSE: PHIN]-г үүсгэн байгуулсан байна.

Салбарын хураангуй:

Автомашин үйлдвэрлэлийн салбар 2022 онд 2.52 их наяд ам.долларын орлоготой ажилласан байна /Statista/. Энэ нь АНУ-ын ДНБ-ийн 9.8 хувийг бүрдүүлсэн бөгөөд тус салбар нь эдийн засгийн голлох секторуудын нэг юм. Түүнчлэн цахилгаан автомашины үйлдвэрлэл тус салбарын хөгжилд ихээхэн нөлөө үзүүлж байгаа бөгөөд үүнтэй зэрэгцүүлэн BorgWarner ePropulsion сегментийн хөгжүүлэлтэнд анхаарлаа хандуулж байна. Компанийн үйлчлүүлэгчдийн дотор Ford, General Motors, Volkswagen болон Stellantis зэрэг үйлдвэрлэгчид ордог бөгөөд тэдгээр нь өөрсдийн загварын цахилгаан автомашин хөгжүүлэлтэнд хөрөнгө оруулж байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд:

BorgWarner Inc компанийн 2023 оны борлуулалтын орлогын динамик:



BorgWarner Inc компанийн голлох харьцаа үзүүлэлтүүд:

	2023	Салбар
Нийт ашгийн маржин	18.09%	19.64%
EBITDA маржин	12.99%	10.05%
Үйл ажиллагааны маржин	8.37%	5.72%
Цэвэр ашгийн маржин	4.40%	2.39%
Эздийн өмчийн өгөөж	9.68%	--
Нийт хөрөнгийн өгөөж	4.46%	3.72%


*Салбарын тооцоололд орсон компаниудыг Хавсралт 3-с харна уу

BorgWarner Inc компанийн 2023 оны борлуулалтын орлогын хэмжээ нь 7 тэрбум 83 сая ам.доллар хүрсэн бөгөөд энэ нь өнгөрсөн онтой харьцуулбал 9.75 хувийн өсөлт юм. Тус компанийн борлуулалтын орлогын 60 гаруй хувийг Air Management сегмент бол цахилгаан автомашины эд ангийн сегмент болох ePropulsion 16 орчим хувийг эзэлдэг байна. Харин үлдсэн хэсэг болох гуравны нэг хэсгийг нь Drivetrain & Battery Systems эзэлдэг байна. Нийт ашиг BorgWarner Inc компанийн хувьд нийт орлогын тавны нэгийг эзэлдэг байна бол цэвэр ашгийн маржин нь 5 гаруй хувьтай байна.



Үнэлгээ:

Refinitiv платформ дээр нийтлэгдсэн шинжээчдийн таамгийг авч үзвэл 2024 оны 6-р сарын байдлаар 3 шинжээч тус компанийн хувьцааг худалдан авахад нэн тохиромжтой гэж үзэж байгаа бол 7 нь худалдан авахад тохиромжтой, 9 нь хүлээх зөвлөмж өгсөн байна.



Эх сурвалж: Refinitiv

Эдгээр тамаг дээр үндэслэн BorgWarner Inc. компанийн дундаж зорилтот ханш 41 ам.доллар дээр тогтож байгаа бөгөөд энэ 6-р сарын 30-ны хаалтын ханшаас 27.17 хувиар дээгүүр ханш юм.

Байгаль орчин, нийгэм, эдийн засаг:

BorgWarner Inc компани 2021 онд автомашин үйлдвэрлэлийн цахилгаанжуулалтыг хурдасгах үүднээс Charging Forward хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна. Компани 2029 он гэхэд борлуулалтын орлогын 50 гаруй хувийг цахилгаан автомашины эд ангийн борлуулалт бүрдүүлэх бөгөөд үнийн дүнгээрээ 10 тэрбум ам.доллар хүрэх төсөөлөлтэй байна. Нийгэм, эдийн засгийн хувьд компанийн ажиллах хүчин олон улсын бүрэлдэхүүнтэй бөгөөд 18.4 хувь нь БНХАУ, 17.8 хувь нь Мексик бол АНУ-д 12.8 хувь ажилладаг байна. Үйлдвэрлэлийн газрууддаа 100 хувь ISO 45001 стандартыг нэвтрүүлсэн байна.

Ингэснээр 2016 оноос 2022 оны хооронд үйлдвэрийн ослын үзүүлэлтийг 200 мянган тутамд 0.72-с 0.37 хүртэл бууруулж чадсан байна.


Томоохон эрсдэлүүд:

- ❑ Charging Forward хөтөлбөрийн үр дүнд компанийн санхүүгийн төлөв байдал өөрчлөгдөх боломжтой
- ❑ Автомашин үйлдвэрлэлийн салбарын чиг хандлага компанийн нийлүүлэлтийн сүлжээнд шууд нөлөөтэй
- ❑ Инфляци болон хэрэглэгчдээс ирж буй бүтээгдэхүүний үнэ бууруулах шаардлага ашгийн үзүүлэлтүүдийг доош татна
- ❑ АНУ-ын хууль зүйн бичиг баримт болон олон улсын худалдааны гэрээ хэлцлүүд өөрчлөгдөж болзошгүй
- ❑ Үйлдвэрчний эвлэлүүд болон ажилчдын нэгдлүүд ажил хаялт зарлаж үйлдвэрлэлийг саатуулах нөхцөл байдал үүсэж болзошгүй
- ❑ Компанийн томоохон үйлчлүүлэгчдийн бүтээгдэхүүний хэрэгцээ болон нийлүүлэгч нарын бараа материалаар хангах чадвар



BWA хувьцааны техник анализ:

abilguun published on TradingView.com, Jul 01, 2024 02:49 UTC-4



TradingView

BWA үнэ ашгийн харьцаа (P/E=11.4)

TRAILING PE

The most recent week's close price divided by the sum of the four most recently reported quarterly earnings.

Trailing PE: 11.4
 5-Year Average: 13.9
 S&P 500 Index Average: 28.4
 Auto & Truck Parts Industry Average: 16.8




BWA үнэ орлогын харьцаа (P/S=0.2)

PRICE TO SALES

The most recent week's close price divided by the revenue per share.

Price to Sales: 0.5
 5-Year Average: 0.7
 S&P 500 Index Average: 2.9
 Auto & Truck Parts Industry Average: 0.6



Хавсралт 3:

TRBC – Auto, Truck & Motorcycle Parts

Компани	Тикер
Lear Corp	LEA
Borgwarner Inc	BWA
Dana Inc	DAN
Visteon Corp	VC.O
LCI Industries	LCII.K
Cooper-Standard Holdings Inc	CPS
Titan International Inc	TWI
Gentherm Inc	THRM.O
Fox Factory Holding Corp	FOX.F.O
Superior Industries International Inc	SUP
Commercial Vehicle Group Inc	CVGI.O
Stoneridge Inc	SRI
Motorcar Parts of America Inc	MCAA.O
Holley Inc	HLLY.K
Mayville Engineering Company Inc	MEC
Xpel Inc	XPEL.O
Sypris Solutions Inc	SYPR.O
Fly-E Group Inc	FLYE.O

Эх сурвалж: Refinitiv

Golomt Capital[®]

Delivering diversity

Мэдэгдэл: Энэхүү мэдээлэл нь Голомт Капитал ҮЦК ХХК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Тухайн мэдээ, мэдээлэл нь урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөж болохыг анхаарна уу. Энэхүү мэдээлэлд тулгуурлаж гаргасан аливаа шийдвэр нь хувь хүн, хуулийн этгээдийн өөрийнх нь эрсдэл болно. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу.

Та шинжээчидтэй холбогдох бол:
8890-9660, 9999-4110, 8806-7847

